

Захиргааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагаар хангах, гаалийн байгууллагын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Гаалийн ерөнхий газрын даргын төрийн захиргаа, хүний нөөц, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр гаргах шийдвэрт дэмжлэг үзүүлэх, гарсан шийдвэр болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын уялдаа холбоо нийцүүлэх, олон нийттэй харилцах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, удирдлагыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Монгол Улсын бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах ажлыг гаалийн байгууллагын хэмжээнд удирдлагаар хангах, зохион байгуулах, хяналт тавих;

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааг уялдуулах, хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд чиглэл өгч, удирдан зохион байгуулах, хяналт тавих;

Гаалийн ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны чиг үүргийг боловсруулах батлуулах, хэрэгжилтийг хангуулах;

Гаалийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичиг болон Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, тайлагнах;

Гаалийн байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, үнэлүүлэх ажлыг зохион байгуулах;

Гаалийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт болон захиргааны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөл, Цахим болон Шуурхай хуралдаан, бусад хурлыг зохион байгуулах, гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

Гаалийн ерөнхий газрын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, стандартын дагуу хөтлөн явуулах ажлыг зохион байгуулах, архивын нэгжүүсгэх;

Гаалийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг олон нийтэд ил тод болгох;

Гаалийн байгууллагын албан хаагчдын “Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг бүртгэх, хяналт тавих, хадгалах, тайлагнах, зохих байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх, авлига, хүнд суртлаас ангид байх ажлыг зохион байгуулах;

Гаалийн улсын байцаагчийн тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулах;

Авлига, хүнд суртлаас ангид, үйлчлүүлэгчээ дээдэлсэн өндөр соёлтой гаалийн үйлчилгээг төлөвшүүлэх;

Гаалийн байгууллагын архивын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавих.

Энэхүү нэгжид Хүний нөөц, хууль эрх зүй, гадаад хамтын ажиллагаа, сургалт болон олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжүүд харьяалагдах бөгөөд тус нэгжүүдийг уялдаа холбоо, удирдлага, арга зүйгээр хангана.

Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд

гаалийн байгууллагын хөгжлийн чиг хандлагатай уялдсан хүний нөөцийн зохистой бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, чиг үүрэгтэй уялдуулан албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах;

Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах; Гаалийн байгууллагын сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, Гаалийн байгууллагад шинээр ажилд орж буй иргэнийг сонгон шалгаруулах;

Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөтөлбөр, хүний нөөцийн асуудлаар холбогдох бодлогын бичиг баримт боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах;

Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем дэх мэдээллийг баяжуулах;

Хүний нөөцийн программыг боловсруулах, гаалийн байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт, баяжилтыг хийж, хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, удирдлагыг судалгаа, мэдээллээр хангах;

Гаалийн байгууллагын албан хаагчдын ажлын цаг ашиглалт, албан томилолтод хяналт тавих зорилгоор гаалийн байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах;

Гаалийн улсын байцаагчийн тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулах;

Албан хаагчдыг албан тушаалд дэвшүүлэх, чөлөөлөх, сэлгэх, хүний нөөцийн бусад асуудлаар судалгааг бэлтгэж, санал боловсруулан шийдвэрлүүлэх;

Гаалийн байгууллагын албан хаагчдын шагнал, урамшуулал, цол, зэрэг дэвийн судалгааг боловсруулах, удирдлагад танилцуулах, олгох ажлыг зохион байгуулах, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах;

Гаалийн байгууллагаас өндөр настны тэтгэвэрт гарсан ахмадуудыг бүртгэх, судалгаанд хамруулах, холбогдох арга хэмжээг зохион байгуулах;

Гаалийн байгууллагын албан хаагчдын эрүүл мэнд, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч ажиллах;

Гаалийн байгууллагын хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн хууль тогтоомж, гаалийн холбогдолтой захиргааны хэм хэмжээний актыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгож, уялдаа холбоог хангах, санал боловсруулах, Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах замаар гаалийн эрх зүйн нэгдсэн орчинг боловсронгуй болгох үндсэн үүргийг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын биелэлтийг гаалийн байгууллагын хэмжээд хангуулах, зохион байгуулах, биелэлтийг тайлагнах;

Гаалийн байгууллагын удирдлагаас батлан гаргасан тушаал, албан бичиг, дүрэм, журам, заавар, аргачлал, гэрээ, хэлэлцээр, баримт бичгийн төслийг боловсруулах явцад эрх зүйн үндэслэлийг хянах, хууль тогтоомжид нийцүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

Гаалийн хууль тогтоомж болон гаалийн хэргийн холбогдолтой бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд судалгаа хийж, санал боловсруулах, шаардлагатай бол гаалийн хууль

тогтоомжийн төсөл боловсруулж, саналыг гаалийн байгууллагын удирдлагаар дамжуулан дээд шатны байгууллагад хүргүүлэх, гаалийн холбогдолтой хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах шатанд холбогдох судалгаа гаргах, тайлбар, танилцуулга хийх ажлыг зохион байгуулах;

Гаалийн байгууллагыг төлөөлөн хууль, хяналтын байгууллагуудтай хуулийн хүрээнд хамтран ажиллах ажлыг зохион байгуулах, хууль хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагад гаалийн албыг төлөөлөн гаалийн холбогдолтой гэмт хэрэгт, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, шинжээчээр ажиллах, албан тушаалтныг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллах;

Гаалийн байгууллагаас батлан гаргасан эрх зүйн актын сан үүсгэх, хэрэгжилтэд хяналт тавьж, давхардал, хийдлийн судалгаа гаргаж, түүнийг арилгах санал боловсруулах, шийдвэрлүүлэх;

Бусад байгууллагаас ирсэн хууль, журмын төсөлд санал өгөх, холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулж Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодод хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

Гаалийн байгууллагаас батлан гаргасан нийтээр дагаж мөрдөгдөх эрх зүйн актыг олон нийтэд таниулах, ил тод болгох ажлыг зохион байгуулах;

Төрийн болон байгууллагын нууцын хууль тогтоомжид нийцүүлэн төрийн нууцын ажлыг хариуцан, нууцын зэрэглэлтэй ирсэн, явсан албан бичгийг бүртгэх, холбогдох албан тушаалтанд танилцуулах, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.

Гадаад хамтын ажиллагааны асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэхэд дэмжлэг үзүүлж, гадаад арга хэмжээг дипломат ёс зүйд нийцүүлэн зохион байгуулах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Олон улсын болон Монгол Улсын дипломат ёслолын бодлогод нийцүүлэн, дипломат харилцааны мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж Гаалийн байгууллагын хоёр болон олон талт гадаад хамтын ажиллагааг зохион байгуулах;

Гаалийн хэргийн чиглэлээр Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ), бусад олон улсын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг, стандарт, зөвлөмж, арга хэрэгслийг үндэсний хэмжээнд хэрэглэх боломжийг судалж санал, зөвлөмж боловсруулах;

Олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламж, техник туслалцааны төсөл, хөтөлбөрт оролцох, хэрэгжүүлэх, хөгжлийн түншлэгч байгууллага хоорондын уялдаа холбоог хангах ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

Гаалийн асуудлаар олон улсын гэрээ байгуулах, хэлэлцээ хийх, нэгдэн орох асуудлыг холбогдох яам, агентлаг болон гаалийн байгууллагын бүтцийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах;

Гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд гаалийн албан хаагч нарыг гадаад улсад уулзалт, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, албан хаагчдын гадаад томилолтын тайланг нэгтгэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулах;

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад баримт бичиг, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх.

Хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн болон хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой олон улсын гэрээ, конвенц, Монгол улсын хууль тогтоомж, түүнтэй уялдуулан гаргасан дүрэм, журам, зааврын

хэрэгжилтийг эрсдэлд суурилан зохион байгуулах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгжийн хариуцсан чиг үүргийн хүрээнд гаалийн байгууллагаас баримтлах бодлогыг тодорхойлох, холбогдох олон улсын бодлогын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулах;

Бусад орны гаалийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, гадаад худалдаанд оролцогч нартай гаалийн хяналт, эрсдэлийн удирдлага, хорио цээрийн чиглэлээр хэрэгжүүлэх мэдээлэл солилцох, хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах;

Харьяа нэгжүүдийн ажлыг уялдуулж, нэгдсэн удирдлагаар хангах;

Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн горим, гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль, тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгох, гаалийн хяналтын тоног төхөөрөмж, гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийг сайжруулах санал боловсруулах, шийдвэрлүүлэх;

Гаалийн баталгаат болон тусгай бүс, гаалийн хяналтын бүс, гаалийн түр агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох санал боловсруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа тэдгээртэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих;

Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа, оюуны өмчийн эрхтэй холбоотой бараанд тавих гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэх;

Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороодыг гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, зөвлөгөө өгөх, хяналт тавих, сургалт зохион байгуулах.

Гадаад худалдааг хөнгөвчлөх зорилгоор цахимаар мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, холбогдох бодлогын даалгавар, санал боловсруулах ажлыг холбогдох газар, хэлтэстэй хамтран хийх;

Энэхүү нэгжид Эрсдэлийн удирдлага, Хорио цээр, Эрэлч нохойн асуудал хариуцсан нэгжүүд харьяалагдах бөгөөд тус нэгжүүдийг уялдаа холбоо, удирдлага, арга зүйгээр хангана.

Эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратегийг тодорхойлж, орчин үеийн мэдээллийн технологийн арга хэрэгсэл ашиглан эрсдэлийн дүн шинжилгээ хийж, гадаад худалдааг хөнгөвчлөх үндсэн үүрэг хүлээнэ.

Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Дэлхийн гаалийн байгууллага, ДХБ болон бусад олон улсын байгууллагаас гаргасан бодлогын баримт бичиг, олон улсын стандартад нийцүүлэн хууль тогтоомж, заавар журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах;

Гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигч, бараанд хийх гаалийн шалгалтын төвшинг тогтоох, шалгалтын үр дүнд дүн шинжилгээ хийх;

Эрсдэлийн мэдээллийн сан үүсгэх, судалгаа, дүн шинжилгээ хийх, эрсдэлийн профайл үүсгэх, холбогдох шалгуур үзүүлэлтийг системд оруулах, үр дүнг тооцох;

ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт тусгасан арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулахад мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган, нэгж хоорондын уялдаа холбоог хангах ажиллах;

Гаалийн харилцаанд оролцогчдын хууль сахилтын төвшинг тодорхойлох, хууль сахилтыг дэмжих, Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

Эрсдэлийн удирдлага, Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн програм хангамжийн хөгжүүлэлт, мэдээллийн сангийн баяжуулалт хийх.

Хорио цээрийн асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтыг хэрэгжүүлж, хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хортон шавж, хог ургамал улсын хилээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хүнсний болон хүнсний бус бараанд хяналт тавих, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалттай холбоотой Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, тэдгээрт нийцүүлэн гаргасан үндэсний хууль тогтоомж, стандарт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллах;

Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах хүний хөл хориот өвчин улсын хилээр нэвтрэн орж ирэх, халдварлах, тархахаас урьдчилан сэргийлэх, өвчний сэжиг илэрсэн тохиолдолд авах хариу арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллах;

Улсын хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсэд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг оновчтой төлөвлөж, хил хяналтын болон мэргэжлийн байгууллагын ажлын уялдааг хангаж ажиллах, хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хортон шавж, хог ургамал улсын хилээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж буй ариутгал, халдваргүйжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллах;

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд экспортын гэрчилгээ, импортын болон хил дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллах;

Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой Засгийн газар хооронд болон хяналтын байгууллага хооронд хэлэлцээр, протокол, санамж бичиг байгуулах, шинэчлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

Гаалийн газар, хороодыг гаалийн хорио цээрийн хяналттай холбоотой удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, зөвлөгөө өгөх, хяналт тавих, сургалт зохион байгуулах.

Тариф, татварын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд Гаалийн тариф, татвар, барааны ангилал, гаалийн үнэлгээ, гарал үүсэлтэй холбоотой Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, улсын төсвийн гаалийн орлого бүрдүүлэх, татварын чөлөөлөлт, гаалийн зуучлагчийн талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, барааны экспорт, импортын статистик болон гаалийн орлогын, захиргааны статистик мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийх, гаалийн лабораторийг бэхжүүлэх, өргөтгөх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, суутгах, буцаан олгох, чөлөөлөх замаар улсын төсвийн гаалийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, улсын төсвийн гаалийн орлогын төлөвлөгөөний төсөл боловсруулж Сангийн яаманд хүргүүлэх, батлагдсан төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг гарган харьяа газар,

хороодод хүргүүлэх, татвар хойшлуулах, өр авлагад хяналт тавих, татвар, хураамж, өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах, гүйцэтгэлд хяналт тавьж, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах, удирдамж чиглэлээр хангах;

Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээг сар бүр боловсруулан гаргаж холбогдох дүн шинжилгээ, судалгаа танилцуулгын хамт УИХ-ын Тамгын газар, Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлэх, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;

Гаалийн болон бусад татварын орлогын ногдуулалт, хураалт, төлөлтийг шударга, үр ашигтай, үр дүнтэй болгох, буцаан олголт, хойшлуулалт, суутган тооцолт, татварын баталгаа гаргах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих, харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэх, нэгтгэл тайлан гаргах, түр горимын дансны үлдэгдэлд хяналт тавьж мэдээ тайланг гаргаж гаалийн газар хороодтой тулгах, баталгаажуулах, улсын төсвийн гаалийн

орлогын биелэлтийг харьяа гаалийн газар, хороодоор гаргаж, түүнд нөлөөлөх шалтгаан нөхцөлийг гадаад худалдааны чиг хандлага, гаалийн бүрдүүлэлттэй уялдуулан тооцоолж, үүрэг даалгавар өгч, хяналт тавьж ажиллах;

Хууль тогтоомжийн дагуу барааг гаалийн болон бусад татвараас чөлөөлөх, татварын чөлөөлөлтөд дүн шинжилгээ хийх, харьяа гаалийн газар, хороодод хийгдсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хяналт тавьж, зөвлөмж, чиглэлээр хангах, шаардлагатай тохиолдолд Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын нэгжүүдтэй хамтран, эсхүл бие даан шалгалт хийх, татварын чөлөөлөлтийн горимтой холбоотой журам, заавар боловсруулах, бүрдүүлэлтийн програмд оруулах, хяналт тавих, Сангийн яамны болон Аудитын байгууллагын төлөвлөгөөт шалгалтад бэлтгэх, шалгалтын зөвлөмж, дүгнэлтийн биелэлтийг хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох ажлыг удирдан зохион байгуулах;

Монгол Улсын нэгдэн орсон гаалийн тариф, татвартай холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээр, Чөлөөт худалдааны хэлэлцээр, түүнтэй адилтгах бүс нутгийн хэлэлцээр, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, бусад татварын тухай хууль тогтоомж, Монгол Улсад мөрдөх гаалийн тарифын жагсаалтын хэрэгжилтийг хангах, УИХ-аас баталсан гаалийн болон бусад татвар, тарифын хувь хэмжээг мөрдүүлэх, санал боловсруулах, судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах;

Дэлхийн худалдааны байгууллагын Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр, болон Дэлхийн гаалийн байгууллагын холбогдох хэлэлцээр, Монгол улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тарифт хамрагдах барааны гарал үүслийг нягтлан шалгах, гаалийн газар, хороодыг зөвлөмж, чиглэлээр хангах ажлыг зохион байгуулах;

Нэгжийн чиг үүргийн дагуу эрх зүйн баримт бичгийн төсөлд санал өгөх, шинээр гарсан хууль эрх зүйн акт, журам, заавар, үйл ажиллагааны үр дүнгийн талаар нийтэд мэдээлэх, татварын чөлөөлөлтийн үйл ажиллагааг ил тод, цахим хяналтад шилжүүлэх, харьяа гаалийн газар, хороодыг удирдлага арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллах, чиг үүрэгтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх.

Энэхүү нэгжид Барааны ангилал, гаалийн үнэлгээ, Статистик, дүн шинжилгээ, Гаалийн төв лабораторийн асуудал хариуцсан нэгжүүд харьяалагдах бөгөөд тус нэгжүүдийг уялдаа холбоо, удирдлага, арга зүйгээр хангана.

Барааны ангилал, гаалийн үнэлгээ хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд барааны ангилал, гаалийн үнэлгээ, гаалийн зуучлагчийн чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, баримт бичиг, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Барааны ангилал, гаалийн үнэлгээний чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний хууль тогтоомж болон бодлогын баримт, бичгийн хэрэгжилтийг хангах;
- Дэлхийн гаалийн байгууллагаас БТКУС-ийн Жагсаалт, Тайлбар бичигт оруулсан

нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх, “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт”, БТКУС-ийн тайлбар бичгийг орчуулах, шинэчлэх, барааны бичиглэлийг ижилсгэх, БТКУС-ийн эталон баазыг хөтлөх;

- Барааны ангиллын үндэсний код, хэмжих нэгжид оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл, санал боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;
- Импорт, экспортын гаалийн үнийн хяналтыг хэрэгжүүлэх, импортын барааны үнийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, баяжуулах;
- Гаалийн бүрдүүлэлтийн явцад барааны ангилал, үнэ, үнэлгээтэй холбоотой асуудлаар харьяа гаалийн газар, хорооны даргын шийдвэрт гаргасан маргаан, гомдлыг шийдвэрлэх; барааны ангиллын урьдчилсан шийдвэр гаргах ажлыг зохион байгуулах;
- Үндэсний хууль тогтоомжийн дагуу барааг кодлох;
- Барааны лавлах санг баяжуулах, боловсронгуй болгох;
- Гадаад худалдаа эрхлэгчдэд холбогдох сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгөх;
- Харьяа гаалийн газар, хороодыг барааны ангилал, үнэ, үнэлгээтэй холбоотой удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
- Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох санал боловсруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллах, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

3.3.3.1 Статистик, дүн шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд барааны экспорт, импортын статистикийн ба захиргааны статистикийн мэдээллийг эрхлэн гаргах, дүн шинжилгээ хийх, төр засгийн удирдах дээд болон бусад байгууллага, хэрэглэгчийг барааны экспорт, импортын статистикийн мэдээллээр хангах, дүн шинжилгээ, зэрэгцүүлэлт хийх, гаалийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, статистикийн мэдээлэл боловсруулах аргачлалыг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэх, мэдүүлгийн санг үнэн зөв бүрдүүлэхэд хяналт тавих үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Барааны экспорт, импортын статистикийн болон захиргааны статистикийн мэдээллийг эрхлэн гаргах, дүн шинжилгээ хийх замаар гаалийн бодлого боловсруулах, мэдээ мэдээлэл боловсруулахад шаардагдах статистик мэдээллээр төрийн болон бусад байгууллагыг хангах, гадаад худалдааны статистикийн мэдээлэл боловсруулах аргачлалыг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэх;

Захиргааны статистикийн мэдээлэл болон хүний нөөцийн асуудлаар байгууллагын стратеги зорилт, үйл ажиллагааг сайжруулах, гаалийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд удирдлагыг мэдээллээр хангах;

Статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх бөгөөд мэдээллийг товч тодорхой байдлаар нэгтгэн боловсруулах, түргэн шуурхай байдлаар цахим технологийг ашиглан удирдлагыг мэдээллээр хангах;

Төр засгийн удирдлага, гаалийн байгууллага, бусад хэрэглэгчийг гадаад худалдааны барааны экспорт, импортын статистикийн болон захиргааны статистикийн мэдээлэл, лавлагаагаар хангах, харьцуулсан дүн шинжилгээ хийх замаар бодлого стратеги боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

Статистикийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор мэдүүлгийн санд хяналт тавих, харьяа гаалийн газар, хороодын гаалийн мэдүүлэгтэй ажиллах болон статистикийн мэдээлэл гаргах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, арга зүйн зөвлөмжөөр хангах;

Статистикийн мэдээллийн аргачлал, арга зүй, мэдээллийн боловсруулалтыг сайжруулах, олон улсын болон мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, шаардлагад нийцүүлэх, статистикийн асуудлаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;

Гадаад худалдааны түнш орнуудтай статистикийн мэдээлэл солилцох, хамтарсан зэрэгцүүлэлт хийж үр дүнг гаалийн зорилгод ашиглах боломжийг бүрдүүлэх;

Цахим технологийг ашиглан статистикийн мэдээллийг нийтэд түгээх;

Их өгөгдлийг боловсруулах, хиймэл оюун ухаанд суурилсан инновацийг нэвтрүүлэх.

Зөрчилтэй тэмцэх, аюулгүй байдлын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах чиглэлээр үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль бус барааны эргэлт, худалдааны луйвар, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хэрэгжүүлэх, мөн байгууллага, мэдээлэл, албан хаагчдын аюулгүй байдал, сахилга, ёс зүйг хангуулах, гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгждараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Дэлхийн гаалийн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага, дотоодын хууль хяналтын болон бусад байгууллага, иргэдээс хүлээн авсан бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоотой мэдээлэл, гомдол, саналыг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх, мэдээлэл солилцох, хууль сахиулах хамтарсан арга хэмжээ зохион байгуулах;

Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох ажлыг зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль хяналтын байгууллага болон зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодтой хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжүүлэх;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хөтөлбөр, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах;

Гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, шийдвэрлэлтэд хяналт тавих;

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих;

Гаалийн зөрчилтэй холбоотой мэдээ, мэдээллийг хүлээн авах, мэдээллийн сан үүсгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийж, онолох, дахин шалгалтын ажиллагааг хэрэгжүүлэх;

Харьяа гаалийн газар, хороодын албан хаагч нараас гаалийн байгууллагын цахим системийн зөрчлийн мэдээллийн санд оруулсан бүртгэл, мэдээллийг хянах, дүн шинжилгээ, судалгаа хийх;

Гаалийн байгууллага, албан хаагчид, барилга байгууламж, мэдээлэл, сүлжээний аюулгүй байдалд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангах;

Гаалийн улсын байцаагчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;

Гаалийн улсын байцаагчийн сахилга ёс зүй зөрчигдөх, ашиг сонирхлын зөрчил үүсэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх.

Энэхүү нэгжид Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдал, Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх асуудал хариуцсан нэгжүүд харьяалагдах бөгөөд тус нэгжүүдийг уялдаа холбоо, удирдлага, арга зүйгээр хангана.

Дотоод хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, дотоод хяналт, шалгалтыг

хэрэгжүүлэх, байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгж дараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцон, эрсдэлийг бууруулах арга хэмжээтэй холбоотой бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллах;

Гаалийн байгууллагын алба хаагч, барилга байгууламж, мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах;

Гаалийн байгууллагын хэмжээнд төсөв, санхүүгийн үйл ажиллагааны явц, үр дүнд дотоод хяналт хийх, эрсдэл тооцож, дүгнэлт өгөх, зөвлөмж чиглэлээр хангах;

Дотоод хяналт, шалгалтын үр дүнгээр Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх газар, харьяа гаалийн газар, хороодод зөвлөмж өгөх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйтэй холбоотой урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;

Гаалийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгах, хуульд нийцүүлэн шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах, Гаалийн ерөнхий газрын Сахилгын хороо болон харьяаллын дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах санал, дүгнэлтийг Гаалийн ерөнхий газрын Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг бэлтгэх, хуралдаан зохион байгуулах, хорооноос гарсан саналыг Гаалийн ерөнхий газрын даргад танилцуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, зөрчлийн үр дагаврыг арилгах, урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулах;

Шаардлагатай тохиолдолд албаны дотоод шалгалтыг явуулахдаа хууль хяналтын байгууллагын дэмжлэгавч, харилцан мэдээлэл солилцон хамтран ажиллах;

Гаалийн байгууллагын албаны нууцтай холбоотой бүх төрлийн мэдээллийн ашиглалт, хадгалалт, аюулгүй байдалд хяналт тавих;

Гаалийн байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааны, барилга байгууламж, мэдээллийн болон программ хангамж, дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих;

Гаалийн байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн болон бусад аюулгүй ажиллагааг хангах, зөвлөмж, чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагаар хангах.

Гаалийн байгууллага, алба хаагчдын аюулгүй байдал, гэмт хэрэгт холбогдсон байдал, сахилга, ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийн санг бүрдүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах.

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хуулийн хүрээнд ашиглах, онилж, илрүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулж, Үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан гаалийн байгууллагын хариуцах ажлын хэрэгжилтийг хангаж, харьяа гаалийн газар, хороодыг удирдлага чиглэлээр хангах, хариуцсан албан хаагчдыг сургалтад хамруулах, мэргэшүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хууль зэрэг хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис болон бэлэн мөнгө улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, шуурхай шалгах ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хөтөлбөр, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрт тусгасан Гаалийн ерөнхий газрын хариуцах ажлын хэрэгжилтийг хангах;

Мэдээлэл хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээнд суурилсан онолох, илрүүлэх, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэх;

Олон улсын болон дотоодын хууль хяналтын байгууллагуудтай хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

Харьяа гаалийн газар, хороодын хар тамхи, мансууруулах бодис болон хууль бус бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, мөнгө угаах, гэмт хэрэг илрүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа хийж удирдлагад танилцуулах;

Хар тамхи, мансууруулах бодис болон хууль бус бэлэн мөнгө, валюттай холбоотой хэрэг, зөрчлийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцад гаалийн хэрэг, зөрчил үйлдэгдэж байж болзошгүй сэжиг, үндэслэл байгаа тохиолдолд гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг цаг алдалгүй зохион байгуулах.

Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд төсөв, хөрөнгө оруулалтын нэгдсэн удирдлагаар хангах, харьяа гаалийн газар, хороод, хилийн боомтын албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хилийн боомтын шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх үндсэн үүргийг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн байгууллагын урсгал төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх, батлагдсан төсвийг хуваарилах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

Гаалийн байгууллагын төсөв, санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, нягтлан бодох бүртгэл хөтлөн холбогдох тайлан, мэдээг гаргах, нэгтгэх, улсын орлогын бараа, үндсэн болон бусад эд хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих;

Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд зохион байгуулалтын удирдлагаар хангах;

Албан хаагчдын нийтлэг баталгаа болон ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, албан үүргээ хэвийн явуулахад шаардагдах дүрэмт хувцас, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтын асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах, хяналт тавих;

Харьяа гаалийн газар, хороодын санхүүгийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

Гаалийн байгууллагын санхүүгийн нэгдсэн тайлан гаргах, дүн шинжилгээ хийх, аудитын байгууллагаар хянуулж, баталгаажуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн удирдлагаар хангах;

Байгууллагын хэмжээнд худалдан авах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй, цахимаар зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцыг хянан шалгаж, баталгаажуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь цахим хуудааст байршуулах;

Боомтыг хөгжүүлэх, хилийн боомтод ажиллах хил, гааль болон бусад хяналтын байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах, хилийн боомтоор нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг саадгүй түргэн нэвтрүүлэх, хилийн боомтын шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хууль ёсны гадаад худалдааг дэмжих үйл ажиллагаанд удирдлага, арга зүйгээр хангах;

Гаалийн байгууллагад хэрэгжих төсөл, арга хэмжээ, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн саналыг холбогдох нэгжтэй хамтран боловсруулах, мэргэжлийн этгээдээр биелэлтийг хангуулах, гүйцэтгэлийн явцад хяналт тавих арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллах.

Энэхүү нэгжид Боомтын хөгжил, Инженер техник, аж ахуй үйлчилгээний асуудал хариуцсан нэгжүүд харьяалагдах бөгөөд тус нэгжүүдийг уялдаа холбоо, удирдлага, арга зүйгээр хангана.

Боомтын хөгжлийн асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд боомтыг хөгжүүлэх, хилийн боомтод ажиллах хил, гааль, бусад хяналтын байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах, хилийн боомтоор нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг саадгүй түргэн нэвтрүүлэх, хилийн боомтын шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хууль ёсны гадаад худалдааг дэмжих үйл ажиллагааг явуулах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Хилийн боомтын барилга байгууламж, дэд бүтцийг өргөтгөж шинэчлэх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, хилийн боомтод ажиллах албан хаагчдын амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар судалгаа хийх, санал боловсруулах ажлыг зохион байгуулах;

Боомтын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний ажлын даалгаварт санал өгөх, барилга байгууламж, зам талбай, дэд бүтэц, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, байршлыг зураг төсөлд тусгуулах ажлыг зохион байгуулах;

Хилийн боомтуудын өргөтгөл, шинэчлэлийн бүтээн байгуулалтын барилгын ажлын захиалагч, гүйцэтгэгч, хэрэглэгч байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах, зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих;

Хилийн боомтуудын барилга байгууламж, дэд бүтцэд хийх засварын ажлын судалгаа гаргах, санал боловсруулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;

Хилийн боомтуудын өргөтгөл, шинэчлэлийн бүтээн байгуулалт, төлөвлөлтийг хөрш орны боомтын шинэчлэлт, бүтээн байгуулалттай уялдуулах, мэдээлэл солилцох, тэргүүн туршлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудит, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн удирдлага, зөвлөмж, чиглэлээр хангах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичиг тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, үр дүнг нэгтгэн тайлагнах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;

Гаалийн ерөнхий газрын стратеги зорилтын хэрэгжилт, төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, үр дүнг нэгтгэн тайлагнах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын

төлөвлөгөөт ажил, үйл ажиллагааны үр дүн болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны үр дүнг дүгнэн, тэдгээрийн хүрэх төвшний шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд явцын болон гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг нэгтгэн шийдвэрлүүлэх, удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;

Гаалийн байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй аян, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, үр дүнг нэгтгэн шийдвэрлүүлэх;

Гаалийн байгууллагын хэмжээнд төсөв, санхүүгийн дотоод аудит (төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээний худалдан авалт, улсын орлогын бараа, санхүүгийн хяналт, шалгалт) хийх, дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах, үр дүнг нэгтгэн тайлагнах, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу нийцлийн аудитыг хийх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулах, үр дүнг нэгтгэн тайлагнах, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;

Хяналт-шинжилгээ, үнэлгээний болон дотоод аудитын үр дүнгээр зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодод зөвлөмж өгөх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох.

Сургалтын асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гааль судлалыг хөгжүүлэх, албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, анхан болон мэргэшүүлэх сургалтыг олон улсын чиг хандлагад үндэслэн зохион байгуулах үндсэн үүргийг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн байгууллагын албан хаагчдын сургалтын бодлого, агуулга, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, гаалийн улсын байцаагчийн мэдлэг, ур чадварын төвшинг дээшлүүлэх, танхимын болон цахим сургалт зохион байгуулах;

Сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэн хөгжүүлэх, орчин үеийн сургалтын заах арга зүй, технологи нэвтрүүлэх, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх;

“Гааль судлал”-ын хүрээнд гаалийн үйл ажиллагааны тулгамдсан асуудал болон гаалийн хэргийг мэргэжлийн төвшинд, шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах арга зүйд суурилсан судалгаа хийх, асуудлыг шийдэх боломжийн талаар санал боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангах;

Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт, гаалийн улсын байцаагчийн давтан, мэргэшүүлэх, ажлын байран дахь сургалт зохион байгуулж, үр дүнг тооцох;

Дэлхийн гаалийн байгууллагын “Цахим сургалт” хөтөлбөрийн багтай холбоо баригчийн үүрэг гүйцэтгэж, албан хаагчдыг цахим хэлбэрээр, зайнаас сургах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох;

Гаалийн харилцаанд оролцогчдын хүсэлтээр захиалгат сургалт явуулах, хууль сахилтын төвшинг дээшлүүлэх чиглэлээр холбогдох нэгжтэй хамтран ажиллах;

Гадаад болон дотоодын ижил чиг үүргийн байгууллагатай хамтран ажиллах;

Сургалтын асуудал хариуцсан нэгжийн багш нарын хичээл заах арга зүй, онол болон практикийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах.

Олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай түгээх ажлыг удирдан зохион байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн байгууллагын нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон гаалийн холбогдолтой хууль тогтоомжийг олон

нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох;

Холбогдох чиг үүрэг хариуцсан нэгжтэй хамтран олон нийтэд түгээх шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулах, гаалийн байгууллагын төлөөлөн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээ, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

Хэвлэл, мэдээллийн байгууллагатай мэдээлэл солилцох, Гаалийн байгууллагыг төлөөлөн хамтран ажиллах;

Гаалийн байгууллагын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах;

Гаалийн байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх, мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг ханган ажиллах, зохион байгуулах, хяналт тавьж ажиллах;

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой видео танилцуулга, бичлэг, хэвлэлийн болон зурагт хуудасны эх бэлтгэх;

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хөндлөнгийн, мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үр дүнг тооцох, үнэлгээний мөрөөр үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах.

Эрэлч нохойн сургалтын асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн эрэлч нохой хөтөлгөч хүний нөөцийг болон гаалийн хяналтад ашиглах эрэлч нохойг бэлтгэх, сургах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн байгууллагад албаны эрэлч нохой ашиглах бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх; Албаны чадамж бүхий эрэлч нохойг сургах, сургалтын агуулга, арга зүй, стандартыг сайжруулах, олон улсын төвшинд боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах;

Гаалийн хяналтад албаны эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх, эрэлч нохойгоор дэмжлэг үзүүлэх;

Гаалийн албанд ашиглаж байгаа эрэлч нохойн үүлдрийн сонголт, нөхөн хангалт, эрүүл мэнд, үржүүлгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

Олон улсын стандартад нийцсэн албаны эрэлч нохойн хоол хүнс, сургалтын байр, талбайг цэвэр, аюулгүй байлгах, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулах;

Гаалийн албанд эрэлч нохой ашиглах онолын болон практик арга зүй эзэмшсэн, гаалийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах;

Харьяа гаалийн газар, хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нарыг нэгдсэн арга зүй, удирдлага, чиглэлээр хангах, сургалт зохион байгуулах;

Эрэлч нохойн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

Албаны эрэлч нохойн сургалттай холбоотой судалгаа хийх;

Гаалийн албанд ажиллаж байгаа нийт албан хаагч нарт албаны нохой ашиглах, нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх арга зүйд сургаж, эрэлч нохойн сургалттай холбоотой мэдлэг мэдээлэл олгох.

Гаалийн лабораторийн асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн хяналт шалгалтын явцад гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, бүтээгдэхүүнд гаалийн зорилгоор магадлан шинжилгээ хийж, барааны нэр төрөл, ангиллын кодыг тодорхойлох, дүгнэлт гаргах, лабораторийн итгэмжлэлийн хүрээг өргөтгөх, шинжилгээний шинэ аргачлалыг нэвтрүүлэх, гаалийн лабораториудыг чадавхжуулах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн зорилгоор магадлан шинжилгээ хийх, барааны нэр төрөл, ангиллын кодыг тодорхойлох, дүгнэлт гаргах;

Харьяа гаалийн газар, хороодын салбар лабораториудын үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах, үнэлэлт дүгнэлт өгөх, бүтэц, орон тоо, зохион байгуулалтын талаар санал боловсруулах, шийдвэрлүүлэх;

Гаалийн төв болон салбар лабораторийг бэхжүүлэх, чадавхжуулах, хилийн боомтууд дээр салбар лабораторийг шинээр байгуулах чиглэлээр санал, төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх;

Лабораторийн бодлогын болон чанарын менежментийн тогтолцооны журам, холбогдох бичиг баримтыг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах, хэрэгжүүлэхэд хяналт тавих,

Гадаад, дотоодын бусад итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллах, харилцан мэдээлэл, туршлага солилцох, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

Лабораторийн үйл ажиллагаа өргөжүүлэх, итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод хамрах хүрээг өргөтгөх, шинжилгээний шинэ арга, аргачлалыг нэвтрүүлэх, аргын болон техникийн нөхцөлийн стандарт боловсруулж, батлуулах, мөрдөх, хэрэгжилтэд хяналт тавих;

Төв болон салбар лабораторийн боловсон хүчнийг бэлтгэх, шинжээчдийн мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах, сургалт зохион байгуулах;

Лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг авах, тоног төхөөрөмжийн оношилгоо, засвар, үйлчилгээг хийлгэх, хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулах, шаардлагатай урвалж бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг захиалах, хангах асуудлыг тавьж шийдвэрлүүлэх;

Төв болон салбар лабораториудын шинжилгээний үр дүнгийн чанар хангалтыг хэрэгжүүлэх, гадаад, дотоод хяналтыг тогтмол зохион байгуулах, дотоод аудитыг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх;

Мэргэжлийн тусгай мэдлэг шаардагдах бараанаас дээж авах, аюултай болон маргаантай барааг шалгах;

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодисыг таньж илрүүлэх магадлан шинжилгээ хийх, энэ чиглэлээр гаалийн улсын байцаагч нарт мэргэжлийн зааварчилгаа өгч, сургалт явуулах.

Гаалийн лабораторийн дүгнэлтийн хэрэгжилтэд хяналт тавих, харьяа гаалийн газар хороодыг мэргэжил арга зүйгээр хангах, үүрэг даалгавар өгөх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах.

Инженер техник, аж ахуй, үйлчилгээний асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, албан хаагчдын ажпаа хэвийн явуулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн байгууллагын барилга байгууламж, хяналтын болон лабораторийн тоног төхөөрөмжийг угсарч, суурилуулах, өргөтгөх, шинэчлэх, худалдан авах ажиллагаанд оролцох, засвар үйлчилгээний талаар судалгаа хийж, хяналт тавих;

Хяналтын болон лабораторийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг оношилгоо, гэмтэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээний талаар холбогдох албан тушаалтанд мэдэгдэл гаргаж, мэргэжлийн байгууллагуудаар асуудлыг шийдвэрлүүлэх;

Гаалийн байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа хяналтын болон лабораторийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийгдсэн боловч баталгаат хугацаанаас өмнө эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд шалтгааныг нь тодруулж засвар үйлчилгээ хийсэн тухайн байгууллагатай хийсэн гэрээ, хэлэлцээрийн заалтыг үндэслэн холбогдох ажлыг зохион байгуулж ажиллана;

Байгууллагын тоног төхөөрөмжийн засварын ажил болон хилийн боомтын төлөвлөлтөд санал, зөвлөгөө өгөх, гүйцэтгэлийн явцад батлагдсан зураг төсөл, норм стандарт, техникийн болон технологийн хяналт тавих, баталгаажуулах, ашиглалтад оруулах

комиссын бүрэлдэхүүнд оролцох;

Барилга байгууламж, засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн зураг төсөл, төсөв боловсруулах ажилд санал өгөх, норм стандартыг хангуулан магадлалаар баталгаажуулах ажилд оролцох;

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын албан хаагч нарын цалин, урамшуулал, тэтгэмжийг тухай бүр олгох, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хууль тогтоомжийн дагуу бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;

Албаны санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд нь үнэн, зөв гаргаж, санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх;

Гаалийн ерөнхий газрын үндсэн болон бусад эд хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, бүрэн бүтэн байдлыг хангах, засвар үйлчилгээ хийх;

Гаалийн ерөнхий газрын албан ажилд унаагаар үйлчлэх, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах;

Гаалийн ерөнхий газрын албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бичиг хэргийн болон бусад эд зүйлс, бараа, материалаар хангах;

Архивын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Гаалийн ерөнхий газрын архивыг эрхэлж, хадгаламжийн нэгж, баримт бичгийг архивд хүлээн авах, цахимжуулах, шилжүүлэх, архивын үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

Гаалийн ерөнхий газрын албан хаагчдын цэвэр, аюулгүй орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, байгууллагын гадна болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ, харуул хамгаалалт, автомашин, дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан хангамж, галын аюулгүй байдал, сантехник болон бусад аж ахуйн засвар үйлчилгээ, цайны газар, автогараж, спорт заал зэрэг үйлчилгээний бүх хэсгийн хэвийн үйл ажиллагааг хангах;

Гаалийн ерөнхий газрын албан хаагчдын эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах.

Мэдээллийн технологийн асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, гаалийн үйл ажиллагааг цахимжуулах, хөгжүүлэх, мэдээллийн систем, өгөгдлийн сан, сүлжээ, серверүүдийн тасралтгүй, хэвийн найдвартай ажиллагааг хангах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийх, гадаад худалдааны статистик мэдээллийг түргэн шуурхай, үнэн зөв гаргах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

Гаалийн үйл ажиллагаанд баримтлах мэдээллийн технологийг тодорхойлох, түүнийг олон улсын стандарт, Дэлхийн Гаалийн Байгууллагын зөвлөмжүүд, Монгол Улсын холбогдох стандарт, шаардлагад нийцүүлж, бусад орны гаалийн байгууллагын хэрэгжүүлж буй дэвшилтэт системийг харьцуулан судалж тэдгээрийн төвшинд хүргэх;

Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, гаалийн үйл ажиллагааг цахимжуулах, хөгжүүлэх, мэдээллийн систем, сүлжээ, серверүүдийн ажиллагааг хангахтай холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналттавих ажлыг зохион байгуулах;

Гаалийн байгууллагын мэдээллийн систем, сүлжээ, серверүүдэд мониторинг хийж, тасралтгүй, хэвийн найдвартай үйл ажиллагаа, нууцлалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;

Харьяа гаалийн газар, хороодын мэдээллийн технологийн ажил үйлчилгээг мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангах, мэдээллийн технологийн чиглэлээр тавигдах шаардлагуудыг тодорхойлох, мөрдүүлэх, хяналттавих;

Мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах;

Гаалийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, нууцлалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох дүрэм, журам боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах;

Гаалийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, ашиглах, өргөжүүлэх (Л/АЫ, МА1\1, 1_АЫ гэх мэт), хэвийн найдвартай ажиллагааг хангах;

Гаалийн албаны үйл ажиллагаанд ашиглаж буй КАЙС, СЕПС болон бусад дэд систем, програм хангамжуудыг захиалагчийн судалгаа, хэрэгцээ, шаардлага, бодлогын даалгаврын дагуу шинээр боловсруулах, турших, нэвтрүүлэх, хөгжүүлэх, сургалт зохион байгуулах;

Гаалийн байгууллагын системийн хэмжээнд ашиглагдах мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн судалгааг хийх, төлөвлөх, хуваарилах, ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийх.

Их өгөгдлийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, хиймэл оюун ухаанд суурилсан инновацийг гаалийн байгууллагад нэвтрүүлэх дэд бүтцийг бий болгох.

Бүрдүүлэлтийн дараах шалгалтын асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд Эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг оновчтой зохион байгуулж, худалдаа эрхлэгч нарын хууль сахилтыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Эрсдэлийн судалгаа болон холбогдох мэдээллийн эх сурвалжаас мэдээ, мэдээлэл цуглуулан, боловсруулалт хийж, бүрдүүлэлтийн дараах шалгалтад ашиглах, шалгалтын үр дүнг эрсдэлийн мэдээллийн санд оруулж, мэдээллийг нэмэгдүүлэх;

Гадаад харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн гаалийн мэдүүлгийн үнэн зөвийг тодорхойлох зорилгоор бүрдүүлэлтийн дараах шалгалтыг зохион байгуулах, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хяналтаас гаргах зөвшөөрөл олгосны дараа гаалийн мэдүүлэг болон гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтад өгөгдсөн мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгах зорилгоор бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг явуулах;

Төрийн болон хууль хяналтын байгууллага, иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл, гомдлыг хүлээн авч, шаардлагатай тохиолдолд бүрдүүлэлтийн дараах шалгалтыг явуулах, мэдээлэл солилцох;

Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичигт нийцүүлэн холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох, өөрчлөх, шинэчлэх;

Гадаад худалдаа эрхлэгчдийн хууль сахилтыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор гаалийн байгууллагад мэдүүлээгүй барааны бүрдүүлэлт хийхтэй холбоотой сайн дураар гаргасан хүсэлтийн дагуу гаалийн нөхөн бүрдүүлэлт хийх;

Гадаад худалдаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд бүрдүүлэлтийн дараах шалгалтын ач холбогдол, үр нөлөөг сурталчлан таниулах, зөвлөгөө өгөх, ил тод, нээлттэй мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.

Нэгдсэн хяналтын асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэхүү нэгж нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги зорилтод нийцүүлэн Гаалийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл явцад гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, теле хяналтын нэгдсэн системийг хослуулан нэгдсэн хяналтыг хэрэгжүүлж, зөвлөмж илгээх, холбогдох нэгжтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа эсэхэд бүрдүүлэлтийн үе шатанд хяналт тавих, Гаалийн ерөнхий газрын удирдлага болон чиг үүргийн нэгжүүдийг мэдээ, мэдээллээр хангах;

Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, теле хяналтын нэгдсэн системийг хослуулан гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох ажлыг зохион байгуулж дэргэдэх байгууллага, харьяа газар хороодын холбогдох нэгжийг мэдээллээр хангаж, үр дүнд дүн шинжилгээ хийх;

Теле хяналтын нэгдсэн систем болон гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, бусад дагалдах хэрэгсэл, програм хангамж, тоног төхөөрөмжийг ашиглан илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх асуудал хариуцсан нэгжид нэн даруй шилжүүлж, хамтран ажиллах; Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээлэл цуглуулах, хүлээн авах, боловсруулах, мэдээллийн сан үүсгэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах;

Их өгөгдлийг боловсруулах, хиймэл оюун ухаанд суурилсан инновацийг хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

Теле хяналтын системийг ашиглан боомтын барилга байгууламж, албан хаагчдын аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

Теле хяналтын нэгдсэн систем болон бусад дагалдах систем, програм хангамж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

Харьяа гаалийн газар, хороодын теле хяналтын дэд системийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлага хүргүүлэх, тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа хийж шийдвэрлүүлэх;

Засгийн газрын гомдол, мэдээлэл хүлээн авах 11-11, Гаалийн лавлах 1800-1281 дугаарын утсаар дамжуулан төрийн хууль хяналтын байгууллага болон аж ахуйн нэгж иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шаардлагатай нэгжид шуурхай хуваарилж, шийдвэрлүүлэх, тайлагнах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах.